

РОССИЙСКАЯ АКАДЕМИЯ НАУК
ИНСТИТУТ ЛИНГВИСТИЧЕСКИХ ИССЛЕДОВАНИЙ

А. М. Певнов

ЧТЕНИЕ
ЧЖУРЧЖЭНСКИХ ПИСЬМЕН

Санкт-Петербург
"НАУКА"
2004

А. М. Певнов, Чтение Чжурчжэньских писем,
(РАН, Институт Лингвистических Исследований)

Санкт-Петербург, 2004, стр. 498 [A. M. Pevnov, *The Jurchen Script, Grammatological Principles and Linguistic Results of Phonoverified Reading*, (Russ. Academy of Sciences, Institute for Linguistic Studies) St. Peterburg, NAUKA, 2004, 498 p.]

Сүүлийн үед оросын эрдэмтэн А. М. Певнов, А. А. Бурыкин нар зөрчид (бага) бичигийн дурасхалыг хэл болон бичгийнхи нь талаас эрчимтэй судлаж байгаа нь монгол хэлний хөгжлийн түүхийн судлалд шууд болон дам холбогдох судлагаа гэж хэлэх үндэстэй юм. 1980-аад оноос манж-хамниганы судлал-аар гаршин ажиллаж, 1992 оны "Вопросы языкознания" сэтгүүлд зөрчид бичгийг тайлан унших тухай томоохон өгүүлэл¹ нийтлүүлж байсан А. М. Певнов авгайн шинэ бүтээлд танилцуулга-шүүмж бичиж байгаадаа сэтгэл хангалуун байна.

Үүнд: -Үсэг бичигийн онолын зарим асуудалууд; - Зөрчид бичиг; -Зөрчид бичигийн зурамыг авиачилан мөшгиж (шалгаж) унших нь; -Зөрчид бичигийн зурамыг авиачилан мөшгиж (шалгаж) уншсаны хэлшижлэлийн үр дүн хэмээх дөрвөн бөлөг, англи товчилол, номзүй, зөрчид бичигийн зурамын жагсаалт зэрэгээс бүрдсэн А. М. Певновын энэхүү бүтээл нь зөрчид хэл, бичигийн судлагаанд өвөрмиц байрыг зүй ёсоор эзлэнэ. Зохиогч эл номдоо И. Е. Гельб (I. E. Gelb) -ийн анх хэрэглэсэн "грамматология" (*Grammatology*) хэмээх нэртөмъёог анхаарч, улмаар зөрчид бичигийн өвөрмиц бүтэцийг тодруулсаны дүнд үсэг бичигийн онолын хүрээнд (*сигнограмма* гэх зэрэг) шинэ агуулга ухагдахууныг заасан нэг бус нэртөмъёо болон (*Фоноверификация чтения графем* гэх зэрэг) судлагааны шинэ аргазүйг оруулж өгчээ.

Зохиогч зөрчид бичигийн зурам (графем)-ыг авиачилан мөшгиж (шалгаж) уншсан үр дүнгээ Цзинь Гуанпин, Цзинь Цицун, Х. Ямази, Г. Кийосэ зэрэг түрүү үеийн зөрчидөч эрдэмтэдийн холбогдох судлагаатай харьцуулан үзээд судлагааны энэ арга нь үгийн гаралсудлалд олон шинэ зүйлийг тодруулах боломж олгож байна хэмээн онцлон тэмдэглэжээ (217-р тал). Тухайлбал, зохиогч урьд өмнө огт мэдэгдэж байгаагүй гэх *-p* (буюу *-r*) –ээр төгссөн үйл үгийн хэлбэрийг шинээр илрүүлсэн тухайгаа дэлгэрэнгүй өгүүлсэн байна (404-412-р тал).

Зөрчид бичигийн дурасхалд монгол хийгээд Алтай овог хэлний хөгжлийн эрт үеийг тодруулах баримт хэрэглэгдэхүүн цөөн бус буй. Тухайлбал: монгол бичигийн хэлний *Mo. śajura-*, хятан хэлний *śaowur*, дундад үеийн монгол хэлний *Mno. śa'ur śa'ura-*; *śa'ura'ul-* хэмээх *цэрэглэ-*, *довтло-*, *дайла-* гэсэн утга бүхий үг нь зөрчид, манж хамниган хэлнээ язгуурын хувьд тохирно гэж

үзэж болно¹. Энэ үгийн зөрчид хувилбарыг А. М. Певновын номоос харж болно (350-р тал, жагсаалт 537). Энэ мэтээр зөрчид бичигийн дурасхалд монгол хэлний "жаргал, дургих, зураг, зургаа(н), мэдээ" гэх зэрэг үгтэй язгуур нэг гэж үзэхүйц үг олон буй. А. М. Певновтой мэргэжил нэг, монголч эрдэмтэн А. А. Бурыкин сүүлийн үед зөрчид бага бичигийн баримтаас олдсон монгол гэх үгийг судлаж хэд хэдэн өгүүлэл нийтлүүлжээ². А. А. Бурыкин тэдгээр 30 гаруй үгийг монгол хэлнээс зөрчид хэлэнд орсон үг хэмээн үзсэн бол энэхүү шүүмжийг бичигч түүнээс арай өөрөөр, тухайлбал, тэдгээр үгийн олонхийг язгуур нэгтэй гэж үзэж болох баримт байгааг үүнээс өмнө нэг бус удаа дурдсан билээ.

Иймээс зөрчид бичигийн дурасхал нь монгол хийгээд алтай овогийн бусад хэлний түүхийг тодруулахад чухал хэрэглэгдэхүүн болдог тул А. М. Певновын нэр бүхий энэ бүтээл нь монгол хэлний судлалд зохих хувь нэмэрээ оруулах болно. Энэ судлагаа нь зөвхөн зөрчид бичигийн тэмдэгийг тайлж (*Свод верифицированных чтений чжурчжэньских фонограмм*: стр. 124-220) уншсаны дүнд гаргаж ирсэн бэлэн үгийн сан (*Свод чжурчжэньской лексики*: стр. 227-362)-гаар хязгаарлагдалгүй, үг бүтэх ёсон зэрэг хэлзүйн асуудал (*Свод чжурчжэньских аффиксов*: стр. 363-382)-ыг давхар хамарсанаараа харьцангуй цогц бүтээл болсон гэдэгийг тэмдэглэвэл зохино.

Энэхүү номыг үзэх явцад санаанд орсон зарим зүйлийг дурдах нь зүйтэй болов уу. Үүнд: 1983 онд Өвөр Монголын Их сургууль (内蒙古大学)-ийн Эрдэм шинжилгээний сэтгүүл (学报)-д Дорж (道尔吉), Хэшиг (和希格) нар зөрчид бичигээр үлдэж ирсэн "Jurchen Yi Yu" (女真译语), "Jurchen Guan Za Zi" (女真馆杂字), "Jurchen Guan Lai Wen" (女真馆来文) хэмээх дурасхалуудын хэлний нарийвчилсан судлагааг багтаасан 438 тал хуудас бүхий (女真译语研究) томоохон бүтээл гаргасаныг мартаж аргагүй буй заа.

Бас нэгэн зүйл: Зохиогч номынхоо 38-р талд "...Закономерен вопрос: почему японцы и корейцы ограничились простым заимствованием китайских сигнограмм, оставив без изменений их начертание, в то время как кидани и чжурчжени решили создать по образцу китайских иероглифов свои собственные письменные знаки? ..." гэсэн асуулт тавиад япон солонгосуудын хувьд хятад, зөрчид нарыг бодоход илүү олон ханз үзэж авсантай холбоотой буй заа хэмээн үзжээ. Гэвч нягтлан үзвээс Солонгосууд Шилла-гийн үеэс эхлэн нэг талаас хятад ханз үсэгийн зуралгыг хялбарчлах, нөгөө талаас солонгос хэлний дуудалгад ойртуулах гэсэн зорилгоор *Hyangch'al*, *Idu*, *kido* хэмээх бичигийн тогтолцоог боловсруулж их бага аль нэгэн хэмжээгээр хэрэглэж байсан баримт буйн дээр Солонгосын Сэжон вангийн үед японы Рюкю аралаас *Kana* хэмээх, ханзаас уламжласан үеийн бичигээр хэвлэсэн ном ирж байсан тухай мэдээ байдагийг мартаж аргагүй юм. Эдгээр баримт бол Солонгос, Японд ханзын зуралгыг хялбарчилах, хэлнийхээ онцлогт тохируулан боловсруулах оролдолго байсан, их бага аль нэгэн хэмжээгээр хэрэглэж ирсэнийг харуулна³.

Мөн зохиогч одоо хэрэглэж буй солонгос бичиг (*Hunmin-jōngŭm*)-ийг гадаад хэлбэрээрээ "...напоминают китайские иероглифы..." (41-р тал) гэж үзсэнтэй санал нийлэхэд хэцүү бөгөөд үгийг үе үеэр нь багцлан холбож бичдэг цагаан толгойт солонгос бичиг нь гадаад хэлбэрээрээ ч, гүн

¹ Ц. Шагдарсүрэн, *Монгол хэлний хөгжлийн эртний үе, түүнийг судласан тойм*, - Эртний монгол хэлний судлал (Монголын судлалын сонгомол өгүүлэлийн эрхи, I хэлмэли: Монгол хэл, II дэвтэр), Улаанбаатар, 1999, (67-125-р х) 71-72-р талаас үзнэ үү!; Ts. Shagdarsureng, *Problems of Methodology of Altaic Comparative Linguistics*, - Польшийн монголч эрдэмтэн С. Калужински профессорын ойд зориулсан эмхидхэл, Варшав, - 2005 (Хэвлэлд).

² А. А. Бурыкин (С-Петербург), *Монгольская лексика в текстах-образцах малого чжурчжэньского письма*, - Проблемы истории и культуры кочевых цивилизаций Центральной Азии, Языки, фольклор, литература, Улан-Удэ, 2000, стр. 52-55; А. А. Бурыкин, *Монгольские и тюркские заимствования в образцах малого чжурчжэньского письма*, - *Altaica*, III, Ulaanbaatar, 2004, pp. 39-66.

³ Lee Ki-moon, *The Hunmin-jōngŭm System*, -Historical Studies on the Korean Writing System, The Korean Studies Series, Vol. 18, Linguistics, 1963, Korean Research Center, Seoul; Л. Лигети, *Табгачский язык-диалект Сяньбийского*, - Народы Азии и Африки, Москва, №1, стр.111; Л. Р. Концевич, *Хунмин Чоным*, - Памятники письменности Востока, Москва, 1979; Ts. Shagdarsurung, *A Study of the Relationship Between the Korean and the Mongolian Scripts*, - *Mongolian Studies*, Tom. XXV, Bloomington, 2002, pp. 59-84 (Cf. p. 63).

ухааны онолын үндэслэлээрээ ч нангиад бичигийн уламжлалаас үлэмжхэн өөр гэдэгийг хэлэх нь зүйтэй болов уу⁴.

А. М. Певнов авгайн энэхүү томоохон бүтээл нь судлагааны төвшин, хамарсан баримт хэрэглэгдэхүүн, эрдэм шинжилгээний үр дүнгийн хувьд зөвхөн зөрчид хэл, бичигийн судлалаар хязгаарлагдахгүй, алтай овог хэлнүүдийн холбоо хамаарал, үгийн гарал-хийгээд бидний хувьд монгол хэлний хөгжилийн түүхийг тодруулах зэрэгт, танилцахад хялбар бус үнэт сурвалж хэрэглэгдэхүүнийг бидний гарт хүргэсэн ач холбогдолтой, сүүлийн хэдэн жилд төдий л олон гараагүй нягт нямбай бүтээлийн нэг гэж үзэх бүрэн үндэстэй юм. Бас монголчуудын үсэг бичиг зөрчид бичиг тулгар зохиоход нөлөөлсөн гэдэг түүхэн баримтын хажуугаар Монголын нутаг дэвсгэрт зөрчид бичигийн дурасхал буй, тэрхүү дурасхалтай нэр холбогдож байсаны хувьд⁵ энэ хэр гүйцэд уншиж амжаагүй уг бичээсийг тайлахад энэ ном аль нэгэн хэмжээгээр хэрэг болно гэдэгийг онцлон тэмдэглэж байна. Энэ жишлэнгээр А. М. Певнов авгайн **“Чтение Чжуржэньских писем”** гэдэг бүтээл нь Алтай овог хэлтэний хэл, бичигийн судлалд гарын авалга, судлагааны үнэт хэрэглэгдэхүүн болно гэдэгт эргэлзэх явдалгүй.

Ц. Шагдарсүрэн

⁴ Ts. Shagdarsurung, *A Study of the Relationship Between the Korean and the Mongolian Scripts*, - *Mongolian Studies*, Tom. XXV, Bloomington, 2002, pp. 59-84.

⁵ Ц. Шагдарсүрэн, *Монголчуудын үсэг бичигийн товчоон (Study of Mongolian Scripts, Graphic Study or Grammarology)*, Улаанбаатар, 2001, 300 тал.